



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/156

Улаанбаатар хот

“Хүндэт өргөмжлөл”-өөр шагнах тухай


Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх заалт, Оюуны өмчийн газрын даргын 2020 оны А/135 дугаар тушаал “Оюуны өмчийн газрын шагналын журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад Прокурорын байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг тохиолдуулан Оюуны өмчийн салбарын эрх эзэмшигчдийн эрхийг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг таслан зогсоох ажилд идэвх санаачилга гарган ажилласан Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх Дорж овогтой Эрдэнэсүвдыг Оюуны өмчийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнасугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, “Хүндэт өргөмжлөл”-ийг гардуулж өгөхийг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР



000677